



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2013 оны 11 сарын 20 өдөр

Дугаар 458

Улаанбаатар хот

“Санар” ХХК-ийн брокер, дилерийн үйл ажиллагаа  
эрхлэх тусгай зөвшөөрлийг сунгах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 6.2, 10.1.5, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Санар” ХХК-ийн брокер, дилерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 3 жилийн хугацаагаар сунгасугай.

2. Хөрөнгө оруулагчид, харилцагчдын хууль ёсны эрх ашгийг дээдлэн Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 210 дугаар тогтоолоор батлагдсан “Монголын компанийн засаглалын кодекс”-ийг мөрдөж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргийг чанд биелүүлж ажиллахыг “Санар” ХХК /Ц.Бүрэнжаргал/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

000802